

## **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИХ СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

ХИС-ийн эрдэм шинжилгээний ажлын онол практикийн түвшинг дээшлүүлэх, судалгааны ажлыг эрчимжүүлэх, докторантуудын судалгааны ажлыг чиглүүлэх, судалгааны арга барилыг эзэмшүүлэхэд нь туслах, ажлын чанар, үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний Их семинар явуулахад энэхүү журам үйлчилнэ.

### **Хоёр. ИХ СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛАХ**

1. Их семинарын зөвлөлийн дарга, гишүүдийг салбарын саналыг үндэслэн хичээлийн жил бүрийн эхэнд захирлын тушаалаар батална.
2. Их семинараар хэлэлцэх докторантын илтгэлийн сэдэв, удирдагч, хугацааг тусгасан салбарын саналыг үндэслэн Их семинарыг зохион байгуулна
3. Нэг удаагийн семинараар 5 хүртэл илтгэлийг хэлэлцэнэ.
4. Их семинараар судалгааны ажлаа үндсэнд нь дуусгасан, удирдагчаасаа бичгээр зөвшөөрөл авсан докторантын ажлыг хэлэлцэнэ.
5. Докторант нь судалгааны ажлынхаа товч танилцуулгыг бэлтгэсэн байна.
6. Докторантын бүтээлийн сэдэв, семинар болох өдөр, цаг, өрөөг 3 хоногийн өмнө гишүүдэд зарлана.
7. Их семинарын зөвлөлийн дарга нь хэлэлцэх ажлын сэдэв, чиглэлд холбогдох мэргэжлийн эрдэмтдийг оролцуулж болно
8. Хэлэлцүүлсэн бүтээлийг шаардлага хангасан гэж үзсэн тохиолдолд докторантыг урьдчилсан хамгаалалтанд оруулах тухай протокол гарна.